



ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2021 онд: 5.1%,  
Инфляци: 2021 онд: 8.2%,  
Урсгал тэнцэл: 2021 онд: -8.3%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2020 оны тайланд прогноз хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>


ДНБ-ий өсөлт: 2021 онд: 6%  
Инфляци: 2021 онд: 5.5%,  
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2021 онд: -13.5%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2020 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3ax1ORq>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

**Төсвийн тэнцэл 7-р сарын байдлаар (831) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.**

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 12.9 хувиар өссөн бол, зарлага 15.3 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 831 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 66.3 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.




**Ам.долларын ханш өмнөх сараас 0.15 төгрөгөөр буурсан байна.**

Долоодугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 12.56 төгрөг буюу 0.4 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 0.15 төгрөгөөр буурч 2848.97 төгрөг болов. 7-р сард гадаад валютын нөөц 4.5 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 3 хувиар буурч, оны эхнээс 0.94 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 26.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




**Инфляцийн түвшин 7.4%**

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2021 оны 7-р сарын байдлаар өмнөх сараас 1.3 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар, оны эхнээс 8.4 хувь өсөв. Инфляцын түвшин 2021 оны 7 дугаар сард улсын хэмжээнд хүнсний бараа, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ тус тус өссөн байна.



**Гадаад худалдааны тэнцэл 903.4 сая.ам долларын ашигтай гарав.**

2021 оны долоодугаар сард нийт барааны эргэлт 8579.8 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 27 хувиар нэмэгдсэн бол экспорт өмнөх сараас 25.1 хувь нэмэгдэж, импорт өмнөх оны мөн үеэс 30.4 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 903.4 сая ам.долларын ашигтай гарав.



## 7-Р САРЫН ОНЦЛОХ: ЗЭЭЛ

Эх сурвалж: [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 7-р сард өмнөх сараас 1.5 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 12.2 хувиар тус тус өсч 19.4 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 1985 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 1.5 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 2.1 хувиар өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 10.2% байна. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 7 дугаар сарын эцэст 19.5 их наяд төгрөг болж, өмнөх сараас 297.0 (1.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 2.1 (12.3%) их наяд төгрөгөөр өссөн байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 9.7 (49.7%) их наяд төгрөг нь иргэдийнх байна.

## САРЫН ОНЦЛОХ

**МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ “В”, ТӨЛВИЙГ “ТОГТВОРТОЙ” ХЭВЭЭР ҮЛДЭЭВ.**

- Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч “Эс энд Пи” агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг “В”, төлвийг “тогтвортой” хэвээр үлдээв. Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал тогтвортой байгааг дараах үндэслэлүүдээр тайлбарлажээ. Үүнд:

Монгол Улсын эдийн засаг цар тахлаас шалтгаалан 2020 онд 5.4 хувиар багассан ч дэлхийн эдийн засгийн сэргэлт, эрдэс бүтээгдэхүүний үнийн өсөлтийн нөлөөгөөр 2021 онд 6.7 хувь, 2022 онд 7 хувьд хүрэхээр байна. Монгол Улсад энэ оны 4 дүгээр сараас Ковид-19-ийн тархалт нэмэгдэж эхэлсэн ч гадаад сектор, улсын төсөв, гадаад өр зэрэгтэй холбоотой үзүүлэлтүүд 2021 оноос сайжирч байгаа тул эдийн засгийн сэргэлт цаашид үргэлжилнэ гэж үзэж байна. Уг сэргэлтэд Монгол Улсын вакцинжуулалтын түвшин, төсвийн зарцуулалтын арга хэмжээ, дэлхийн эдийн засгийн сэргэлтээс үүдэлтэй эрдэс бүтээгдэхүүний экспортын өсөлт зэрэг хүчин зүйлс нөлөөлнө. Монгол Улсын вакцинжуулалтын түвшин бусад хөгжиж буй улстай харьцуулахад их байгаа нь цар тахлаас шалтгаалсан эдийн засгийн тодорхой бус байдлыг бууруулж байна. Монгол Улсын нийт иргэдийн гуравны хоёр хувь нь вакцины нэг тунг хийлгэсэн бөгөөд 60-аас дээш хувь нь вакцинд бүрэн хамрагджээ. Уул уурхайн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөлөөгөөр дунд хугацаанд эдийн засгийн төлөв харьцангуй таатай байх нь “Таван толгой”, “Оюу толгой”-н уул уурхайн төсөл дэх гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөлөөгөөр эдийн засгийн өсөлт 2024 он хүртэл дунджаар 6.8 хувь орчимд байх аж. Мөн нэг хүнд ногдох ДНБ-ээр ижил төстэй бусад улстай харьцуулахад Монгол Улсын эдийн засгийн өсөлт дунд хугацаанд өндөр байхаар төсөөлж байна.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 7-р сар 2021 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 7-р сар 2021 он, Монголбанк
- [www.1212.mn](http://www.1212.mn), [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn), [www.montsame.mn](http://www.montsame.mn).